



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 460

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалт, Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2021 оны 01-07-020/42 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч дахин үнэлгээнд хамрагдсан, сэргээн засварлах боломжгүй болсон ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 3,100,874,890.00 (гурван тэрбум нэг зуун сая найман зуун далан дөрвөн мянга найман зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 736,593,521.76 (долоон зуун гучин зургаан сая таван зуун ерэн гурван мянга таван зуун хорин нэгэн төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Тамир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Газрыг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, төрийн өмчийн барилга барихаас өөрөөр ашиглахгүй байх;


2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2021-оны 10-дугаар сарын 19-ний өдрийн  
 /16/ дугаар тогтоолын хавсралт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын  
 үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгө

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын 1 дүгээр байр /Протез, ортопедийн үйлдвэрийн байр/, /2 давхар, нийт талбай 1397,29м2/	1978	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5	3,100,874,890.00	736,593,521.76	2,364,281,368.24
	Нийт дүн			3,100,874,890.00 /гурван тэрбум нэг зуун сая найман зуун далан дөрвөн мянга найман зуун ерэн/	736,593,521.76 /долоон зуун гучин зургаан сая таван зуун ерэн гурван мянга таван зуун хорин нэгэн төгрөг далан зургаан мөнгө/	2,364,281,368.24 /хоёр тэрбум гурван зуун жаран дөрвөн сая хоёр зуун наян нэгэн мянга гурван зуун жаран найман төгрөг хорин дөрвөн мөнгө/